



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ГИШҮҮНИЙ ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа
үүсгэх тухай**

Иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж "Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад "нэр дэвшигч" гэж 50 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын уугуул иргэнийг;" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийг; мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн" гэсэн мэдээлэл ирүүлжээ. Уг мэдээлэлд холбогдох үндэслэл, тайлбарыг тусгаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтын холбогдох хэсгийг зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэж өгөхийг хүссэн байна.


ҮНДЭСЛЭЛ:

Иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нарын мэдээлэлд дурдсан асуудал нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарч байх тул уг асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлтэй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1.Иргэн Т.Доржханд, Д.Үүрцайх нарын мэдээллийн дагуу Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийг; мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа тус тус үүсгэсүгэй.

ГИШҮҮН



Д.СОЛОНГО